



ДАРХАН-УУЛ АЙМАГ
“ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 9/55

Дархан

Техникийн нөхцөл олгох комисс
шинэчлэн байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.3, Эрчим хүчний сайдын 2013 оны 03 дугаар тушаалаар батлагдсан “Дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1, Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан “Дулаан дамжуулах, түгээх сүлжээний холболтын журам”, “ДДС” ТӨХК-ийн хөдөлмөрийн дотоод журмын 3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Дархан-Уул аймгийн Дархан сумын төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд 1.0 Гкал/цаг хүртэл дулааны ачаалал бүхий барилга байгууламжийг холбох “Дулааны техникийн нөхцөл олгох комисс”-ыг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга :	-Ерөнхий инженер
Нарийн бичгийн дарга:	-Горимын инженер
Гишүүд:	-Төлөвлөлт, бодлого, зохицуулалтын албаны дарга
	- Дулаан дамжуулах албаны дарга
	- Дотоод хяналтын хэлтсийн дарга
	- Дулаан түгээх, хангах албаны дарга
	- Зургийн инженер
	-“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн ерөнхий инженер
	- Дархан-Уул аймгийн ерөнхий архитектур

2. Дулааны техникийн нөхцөл олгох комисст ДААЛГАХ нь:

а/. Холбогдох дүрэм, журмыг баримтлан холболтын цэг дээрх чадлын хязгаарын дотор дулаан дамжуулах, түгээх сүлжээний шугам хоолойн нэвтрүүлэх чадварыг харгалзан хэрэглэгчийн гаргасан хүсэлт, холбогдох бичиг баримтыг үндэслэн техникийн нөхцөл олгож байх

2025.03.10


б/. 1.0 Гкал/цагаас дээш дулааны ачаалалтай барилга байгууламжид техникийн нөхцөл олгох хүсэлтийг Эрчим хүчний яамны техникийн нөхцөл олгох ажлын хэсэгт уламжилж байх

в/. Дархан-Уул аймгийн Засаг даргын захирамжаар нэг хэсэг газар /томоохон/ буюу хороолол хамарсан газар олгосон тохиолдолд тэдгээрийг бүхэлд нь хамарсан шугам сүлжээ, дулаан хуваарилах төв барих асуудлыг техникийн нөхцөлд тэмдэглэж байх

г/. Олгосон техникийн нөхцлийн шаардлагыг хангасан барилга байгууламжийг дулааны сүлжээнд холбуулах, угсралтын ажлын явцад техникийн хяналт тавих ажлыг зохион байгуулах, техникийн олгох ажиллагааг ил тод, нээлттэй, шударга байлгах

3. Энэ тушаал батлагдан гарсантай холбогдуулан “ДДС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн а/32 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.БАТЖАРГАЛ